



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 289

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа газар, хороодын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 127,210,750.00 (нэг зуун хорин долоон сая хоёр зуун арван мянга долоон зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 95,068,141.97 (ерэн таван сая жаран найман мянга нэг зуун дөчин нэгэн төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Эрчим хүчний төрийн өмчит хувьцаат компаниудад балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Г.ГАВАА



0001551

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 6 дугаар сарын 25-ний өдрийн
...дугаар тогтоолын хавсралт

**Гаалийн өрөнхий газрын харьяа газар, хороодын балансаас
Эрчим хүчиний төрийн өмчтөг компаниудын балансад шилжүүлэх хөрөнгийн ж**

Д/д	Шилжүүлэн өгөх байгууллага	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ (төгрөг)	Хурийтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Сүхбаатар аймаг дахь Бичигт дэх гаалийн газар	10кВт цахилгаан шугам	2004.04.18	ш	1	16,102,850.00	14,581,885.83	1,520,964.17	"Дорнод бусийн эрчим хүчин систем" ТӨХК
2		Трансформатор	2007.05.10	ш	1	6,392,400.00	1,932,940.00	4,459,460.00	
3		Трансформатор	2011.12.31	ш	1	10,933,756.00	4,312,759.39	6,620,996.61	
4		Цахилгаан кабель	2011.12.31	ш	1	3,271,744.00	1,290,521.56	1,981,222.44	
5	Ховд аймаг дахь гаалийн газар	Эрчим хүчиний дэд станц	2007.05.24	ш	1	30,609,990.00	16,596,825.46	14,013,164.54	"Баруун бусийн эрчим хүчиний систем" ТӨХК
6	Завхан аймийн Арцсуурь дахь гаалийн хороо	Цахилгаан дамжуулах дэд шугам	2004.12.31	ш	1	40,300,010.00	40,300,010.00	0	"Алтай Улиастайн эрчим хүчиний систем" ТӨХК
7		Ил дэд станц	2001.07.07	ш	1	9,800,000.00	9,800,000.00	0	
8	Өмнөговь аймгийн Гашуунсухайт дахь гаалийн газар	Трансформатор	2006.12.01	ш	1	9,800,000.00	6,253,199.73	3,546,800.27	"Өмнөд бусийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК
							95,068,141.97 (ерэн таван сая жаран найман мянга нэг зуун дэчин нэгэн долоон зуун төгрөг өрэн тавин)	32,142,608.03 (гучин хоёр сая нэг зуун дэчин хоёр мянга зургаан зуун найман төгрөг долоон мөнгө)	НИЙТ ДҮН:
							127,210,750.00 (нэг зуун хорин долоон сая хоёр зуун арван мянга долоон зуун төгрөг өрэн тавин)	8	